



## БУЛГАН АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2024 оны 10 сарын 15-өдөр

Дугаар A/682

Булган сум

Г Ажлын хэсэг байгуулж, хөрөнгө  
гаргах тухай

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.1, 60.1.2, 66 дугаар зүйлийн 66.1 дэх заалт, Улсын Их Хурлын 2024 оны 21 дүгээр тогтоолоор батлагдсан "Монгол улсын Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөр"-ийн 2.3.1 дэх заалт, аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2024 оны XXV дугаар хуралдааны "Булган аймгийн 2024 оны төсөвт өөрчлөлт оруулах тухай" XXV/05 дугаар тогтоолыг тус тус үндэслэн  
**ЗАХИРАМЖЛАХ** нь:

1.Хөдөөгийн хүн амд чиглэсэн төрийн үйлчилгээний хүртээмжийг нэмэгдүүлэх, нийгмийн суурь үйлчилгээг нэг дороос хурдан шуурхай, чанартай хүргэх зорилгоор нэгдсэн арга хэмжээг аймгийн хэмжээнд зохион байгуулсугай.

2.Дээрх нэгдсэн арга хэмжээг зохион байгуулах аймгийн ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэйгээр томилсугай. Үүнд:

Ажлын хэсгийн дарга: М.Батчимэг – (Аймгийн Засаг даргын Тамгын газрын  
Нийгмийн бодлогын хэлтсийн дарга)

Гишүүд:  
А.Оюунжаргал - (Аймгийн Засаг даргын Тамгын газрын  
Нийгмийн бодлогын хэлтсийн мэргэжилтэн)  
Н.Батжаргал – (Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний  
газрын дарга)

С.Оюунзаяа – (Хүүхэд, гэр бүл хөгжил, хамгааллын газар)  
П.Оюунцэцэг – (Эрүүл мэндийн газрын дарга)  
Д.Нарантуяа – (Эрүүл мэндийн газрын Нийгмийн эрүүл  
мэндийн хэлтсийн дарга)  
Д.Зоригтбаатар - (Нэгдсэн эмнэлгийн дарга)

С.Ерөө – (Нэгдсэн эмнэлгийн дотрын эмч)

М.Наранхишиг – (Нэгдсэн эмнэлгийн эх барих

эмэгтэйчүүдийн эмч)

М.Ариунаа - (Нэгдсэн эмнэлгийн шүдний эмч)

Г.Цэрэнлхам - (Нэгдсэн эмнэлгийн сүрьеэгийн эмч)

А.Оюунсууд - (Нэгдсэн эмнэлгийн рентген техникич)

Нарийн бичгийн дарга: М.Солонго – (Аймгийн Засаг даргын Тамгын газрын

Нийгмийн бодлогын хэлтсийн ахлах мэргэжилтэн)

3.Арга хэмжээний удирдамжийг 1 дүгээр, төсвийг 2 дугаар хавсралтаар баталсугай.

4.Арга хэмжээг чанартай, хурдан шуурхай зохион байгуулж, мэргэжил арга зүй, удирдлагаар ханган хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг ажлын хэсгийн дарга, Нийгмийн бодлогын хэлтэс (М.Батчимэг)-т даалгасугай.

5.Дээрх нэгдсэн арга хэмжээг зохион байгуулахад шаардагдах 2,105,360 (хоёр сая нэг зуун таван мянга гурван зуун жаран) төгрөгийг “Эрүүл мэнд” хөтөлбөрийн зардлаас санхүүжүүлэхийг Засаг даргын Тамгын газар (Д.Алтаншагай)-т зөвшөөрсүгэй.



Аймгийн Засаг даргын 2024 оны ... дугаар сарын  
.... едрийн .... дугаар захирамжийн .... дүгээр хавсралт

**АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН НЭРЭМЖИТ НИЙГМИЙН ҮЙЛЧИЛГЭЭГ ЦОГЦООР ХУРГЭХ  
НЭГДСЭН АРГА ХЭМЖЭЭНИЙ ЕРӨНХИЙ УДИРДАМЖ**

**ҮНДЭСЛЭЛ:** 2023 оны жилийн эцсийн байдлаар манай аймаг 19328 өрхөд 60535 иргэд бүртгэгдсэн бөгөөд үүнээс 74,5 хувь нь хөдөө орон нутагт ажиллаж, амьдарч байна. Хүн амын дийлэнх нь хөдөө тархан суурьшиж байгаа нь нийгмийн суурь үйлчилгээг түргэн шуурхай авах, аймгийн төврүү явах шаардлагатай болох, мэдээлэл авахад хундрэлтэй байх бэрхшээл байсаар байна.

Хөдөөгийн иргэдэд чиглэсэн төрийн байгууллагуудын үйлчилгээг нэг доорос саадгүй хүргэх зорилгоор 2022-2023 онд "Хүрч үйлчлье" арга хэмжээг 16 сум, 1 тосгонд зохион байгуулж, нарийн мэргэжлийн эмч нарын үзлэг, шинжилгээ, оношлогоо, нийгмийн даатгалын үйлчилгээ, зорилтот бүлгийн өрхүүдтэй биечлэн уулзаж, тулгамдсан асуудлыг шийдвэрлэх, боловсролын үйлчилгээний хүртээмж, багш, ажилчдын уулзалт, хүн амын бие бялдарын түвшин тогтоох сорилт иргэдийг хамруулах зэрэг арга хэмжээг зохион байгуулж, тодорхой үр дүнд хүрсэн.

Цаашид алслагдсан сумын иргэдэд халдварт болон халдварт бус өвчнөө эрт илрүүлэх, эрүүл мэндийн даатгалд хамрагдах, боловсрол, нийгмийн халамжийн болон соёл, үрлагийн үйлчилгээг авах хэрэгцээ байсаар байна.

**ЗОРИЛГО:** Хөдөөгийн хүн амд чиглэсэн төрийн үйлчилгээний хүртээмжийг нэмэгдүүлэх, түүнчлэн нийгмийн суурь үйлчилгээг (эрүүл мэнд, нийгмийн даатгал, халамж, хөдөлмөр эрхлэлт, боловсрол, биеийн тамир) нэг доорос хурдан, шуурхай хүргэх замаар нийгмийн салбарын байгууллагуудын үйл ажиллагааны давхардал, үр ашиггүй байдлыг багасгахын зэрэгцээ тэдгээрийн хоорондын уялдаа холбоог сайжруулж, хамтын ажиллагааг дэмжих зорилготой.

**УДИРДЛАГА, ЗОХИОН БАЙГУУЛАЛТ:** аймгийн Засаг даргын захирамжаар батлагдсан ажлын хэсэг тус арга хэмжээг удирдан чиглүүлж, нийгмийн салбарын байгууллагуудын хамтын ажиллагааны хүрээнд сумын ЗДТГ-тай хамтран зохион байгуулна.

**ХАМРАХ ХҮРЭЭ, ХЭРЭГЖҮҮЛЭХ ХУГАЦАА:** 13 сум 1 тосгонд нийгмийн үйлчилгээг хүргэх үйл ажиллагаа зохион байгуулж, 0-17 наасны хүүхэд, 18-34 наасны залуучууд, төрийн албан хаагчид, зорилтот өрхийн гишууд, малчид, хувиараа хөдөлмөр эрхлэгчид, ажилгүй иргэдийг хамруулна.

Сайхан суманд- 2024 оны 10 дугаар сарын 16-17 өдөр  
Баян-Агт суманд- 2024 оны 10 дугаар сарын 18-19 өдөр

**ХЭРЭГЖҮҮЛЭХ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЧИГЛЭЛ:**

- Хүн амд эрүүл мэндийн тусlamж үйлчилгээг ЭМГ-аас тусгай удирдамжийн дагуу дараах чиглэлээр хүргэнэ. Үүнд:

- Хүн амын нас, хүйс, эрүүл мэндийн эрсдэлд суурилсан зонхилон тохиолдох халдварт болон халдварт бус өвчнөөс урьдчилан сэргийлэх, эрт илрүүлэг үзлэг, шинжилгээ, оношлогоог зохион байгуулах
  - 2-17 насны хүүхдүүдийн насны онцлогт тохирсон аргачлалаар шүд цоорох өвчний хор уршиг, шүдээ зөв угаах дадал олгох сургалтыг зохион байгуулах
  - Хүүхдүүдийг шүд, амны хөндийн үзлэгт хамруулж, шүд цоорох өвчтэй хүүхдүүдийг эмчлэх арга хэмжээг хэрэгжүүлэх
  - Сумын эрүүл мэндийн төвүүдэд мэргэжилт арга зүйн зөвлөмжөөр хангах
  - Сүрьеэгийн идэвхитэй илрүүлэг үзлэгт зорилтот бүлгийн хүн амыг хамруулах
2. Нийгмийн даатгал, эрүүл мэндийн даатгалын үйлчилгээний чанар, хүртээмжийг нэмэгдүүлэх, даатгалын хамрагдалтыг нэмэгдүүлэх чиглэлээр тусгай үдирдамжийн дагуу дараах үйл ажиллагааг хэрэгжүүлнэ. Үүнд:
- Эрүүл мэндийн даатгалд хамрагдах ач холбогдлын талаар иргэдэд мэдээлэл өгөх уулзалтыг сумын ЗДТГ-тай хамтран зохион байгуулах
  - Зорилтот өрхийн гишүүдийг эрүүл мэндийн даатгалд хамруулах
3. Хүүхдийн хөгжил, оролцооны чиглэлээр хийгдэх ажил:
- Сумдын үдирдлагуудтай хамтран "Хүүхдээ сонсъё" арга хэмжээг зохион байгуулж, тулгамдаж буй асуудлыг шийдвэрлэх
  - Сум бүрд хүүхдийн өөрийн үдирдлагын байгууллага, хүүхэд өсвөр үеийнхний төлөө ажиллах "Хүүхдийн элч"-ийг сонгох
  - Хүүхдийн өөрийн үдирдлагын байгууллага, хүүхдийн зөвлөлийн 2023-2024 оны хичээлийн жилийн үйл ажиллагааны тайланг танилцуулах
  - Тусгай хэрэгцээт хүүхдүүдийн талаар үе тэнгийнхэнд зориулсан "Хамтдаа хөгжье" сургалт нөлөөллийн ажил зохион байгуулж, мэдээллээр хангах
  - Аймгийн хэмжээнд дотуур байрны хүүхдүүдийн судалгаа гаргаж, хүүхэд хөгжлийн өрөөг тохижуулах ажилд хүүхдүүдээс санал авах
  - Эрсдэлт нөхцөл байгаа хүүхдийн судалгааг шинэчлэн гаргах
  - Сумдын үдирдлагууд, сумын нийгмийн ажилтан, сургуулийн нийгмийн ажилтнуудтай уулзалт, ярилцлага хийх.
4. Хөдөлмөр, нийгэм хамгааллын үйлчилгээний чиглэлээр дараах арга хэмжээг хэрэгжүүлнэ. Үүнд:
- Зорилтот 20 өрхөөр зочлон өрхийн гишүүдтэй уулзалт, ярилцлага зохион байгуулан, нөхцөл байдлын үнэлгээ хийж, өрхийн орлогыг нэмэгдүүлэх талаар мэдээллээр хангах
  - Сумын нийгмийн бодлогын мэргэжилтэн, халамжийн мэргэжилтнүүдтэй хамтран хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүдийн статистик тоон мэдээллийг шинэчлэх (Байнгын асаргаатай болон, боловсролын үйлчилгээнд хамрагдаагүй хүүхдийн тоо, ЕБС-д суралцдаг, СӨБ-д хамрагдаж буй хүүхдийн тоо) ажлыг зохион байгуулах
  - Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүдэд болон асран хамгаалагчдад тулгамдаж байгаа асуудлуудыг сонсож, бодлого төлөвлөлтэд тусгах, хэвтрэйн болон байнгын асаргаатай хүүхдүүдэд гэрийн зргэлт хийх.
  - НҮБ-ын хүүхдийн сангаас орон нутагт ирүүлсэн хандив тусlamжийг сумдын зорилтот өрхийн хүүхдүүдэд хүргэх

## ХҮРЭХ ҮР ДҮН:

- Урьдчилан сэргийлэх, эрт илрүүлэх үзлэгт 0-17 насны хүүхэд, 18-34 насны залуучууд, төрийн албан хаагч, зорилтот өрхийн гишүүдийг хамруулсан байх
- 16 сум 1 тосгонд 2-17 насны хүүхдүүд шүд цоорох өвчний хор уршгийн талаар мэдлэгээ тэлж, шүдээ зөв угаах дадалд суралцсан байна.
- Амны хөндийн өвчлөлийг илрүүлэн, эмчилсэн байна
- Эрүүл мэндийн даатгалд хамрагдаагүй иргэдийг сайн дурын даатгалд хамруулсан байх
- Иргэдэд чиглэсэн сургалт, нөлөөллийн арга хэмжээнд 500-аас доошгүй иргэдийг хамруулсан байх
- Сумдын хүүхдүүдийн "Хүүхдээ сонсьё" арга хэмжээг зохион байгуулагдаж, арга хэмжээнээс гарсан саналууд шийдвэрлэгдсэн байна
- Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүдэд болон асран хамгаалагчид, хэвтрийн болон байнгын асаргаатай хүүхдүүдэд гэрийн эргэлт хийгдэж, тулгамдаж буй асуудлыг нэгтгэн бодлого төлөвлөлтэд тусгах, сум орон нутгаас хамааралтай шийдэж болох асуудлуудыг шийдвэрлэсэн байна.
- Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүд болон эрсдэлт нөхцөлд байгаа хүүхдүүдийн статистик тоон судалгаа шинэчлэгдсэн байна.
- Дотуур байрны хүүхдүүдийн судалгаа шинэчлэгдэж, охид ба хөвгүүдэд зориулсан жишиг хөгжлийн өрөөг шаардлагатай сумдад байгуулагдсан байна.
- Дотуур байрны охид болон сургуулийн эмэгтэй бие засах өрөөнд "Нандин хайрцаг" –ийг технологийн багш нартай хамтран байршуулсан байна.
- НҮБ-ын хүүхдийн сангаас орон нутагт ирүүлсэн хандив тусlamжийг сумдын зорилтот өрхийн болон, зудын бүсэд байгаа хүүхдүүдэд хүргэгдсэн байна.

Аймгийн Засаг даргын 2024 оны 10 дугаар сарын  
15. өдрийн 160 дугаар захирамжийн 2 дугаар хавсралт

АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН НЭРЭМЖИТ НИЙГМИЙН ҮЙЛЧИЛГЭЭГ ЦОГЦООР ХУРГЭХ  
НЭГДСЭН АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨСӨВ

Шаардагдах зардал	Хэмжих нэгж	Тоо ширхэг	Нэг бүрийн үнэ	Нийт
Шатахууны зардал (4 машин 430 км) АИ-92	Литр	309	2520	778,680
Шатахууны зардал (2 машин 430 км) Дизель тулш	Литр	154	3420	526,680
Зорилтот өрхөд олгох хүнсний багц	Багц	40	20,000	800,000
НИЙТ ДҮН				2,105,360